

**ХОРООНЫ ДУГУЙН ЗАМ, ТОХИЖИЛТ**  
**/Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/**  
**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2020 оны 7-р сарын 31-ны өдөр

Дугаар *2020/66*

Улаанбаатар хот

1.	Төсөл боловсруулах үндэслэл	-2020 оны төсвийн тухай хуулийн XI.2.62 дугаар заалт -Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/353 дугаар захирамж -Улсын их хурлын гишүүн С.Батболдын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 1836 тоот албан бичиг
2.	Тохижилт хийх байршил	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
3.	Онцгой нөхцөл	- Тендерт ирүүлэх төсвийг зохиохдоо заавал тохижилт хийх байршил, ажлын талбарт очиж, хэмжилт хийн фото зургаар баталгаажуулах - Батлагдсан төсөвт өртөгт багтах хэмжээгээр ажлын зураг, төсвийг боловсруулах - Батлагдсан зургийн даалгаварт 2 төсөл арга хэмжээ тусгагдсан болно
4.	Төслийн иж бүрдэл	<b>1. Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт</b> Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн <b>ЗД2020/002</b> дугаартай дугуйн зам шинээр барих ажлын зураг төсөл боловсруулах даалгаварын 2 дугаар хэсэгт заасны дагуу Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт төсөвт өртөгт багтаан хийх.

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН

ЗТХ-ИЙН ДАРГА

..... /Б.ЛХАГВАЖАВ/

БОЛОВСРУУЛСАН:

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН

ЗТХ-ИЙН ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

*[Signature]* ..... /В.СУВД-ЭРДЭНЭ/

БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН ЗАМ, ТЭЭВРИЙН  
АСУУДАЛ ХАРИУЦСАН  
ТӨСЛҮҮДИЙН УДИРДАГЧ




Б.ОТГОНСҮХ

ДУГУЙН ЗАМ ШИНЭЭР БАРИХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ  
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

ЗӨВШӨӨРСӨН:

НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ИНДРА

Дугаар ЗД2020/002

1. Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/353 дугаартай захирамж - Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын 2020 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн З/2229 дугаартай албан тоот - Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн ГБМЗХ2020/20-003 дугаартай тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар - Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын 2017 оны Сэлбэ голын дагуух унадаг дугуйн замын судалгаа
2. Байршил	Сүхбаатар дүүрэг, 13, 14, 15, 16, 17, 19 дүгээр хороо
3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Улсын төсөв
4. Замын техникийн ангилал, замын зэрэг	Дугуйн зам
5. Газрын бартаалаг, төвөгшил	Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНБД-ээс харах
6. Замын хучилтын хийц	Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ
7. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай 2020 он
8. Зураг төслийн байгууллага	Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага
9. Захиалагч байгууллага	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ
10. Зураг төслийн иж бүрдэл	1. Инженер геодезийн ажлын тайлан 2. Инженер-геологийн судалгааны ажлын тайлан 3. Дугуйн замын ажлын зураг төсөл 4. Тайлбар бичиг (Трасс сонголт, төлөвлөлтийн хувилбар, холбогдох норм ба дүрэм, төлөвлөлтийн шийдлийн талаар,

	<p>төслийн товч танилцуулга, ажлын тоо хэмжээ, хучилтын бүтээц, тооцоо, магадлалын ерөнхий дүгнэлт)</p> <p>5. Техникийн шаардлага</p> <p>6. Барилгын ажлын нэгдсэн төсөв</p>
<p>11. Онцгой нөхцөл:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Зураг төсөл боловсруулахдаа Монгол улсад мөрдөж буй “Авто зам төсөллөх” 33БНБД 22-004-2016, “Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ” БД81-104-02, “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04, “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” БД31.101.04, “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНБД 32-02-12, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009, “Замын байгууламж. Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага MNS 5683:2016”, “Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага”MNS 4597: 2014, “Авто замын тэмдэглэл” MNS4759:2014, “Авто замын гэрлэн дохио” MNS 4980:2014, “Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам” болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх. Мөн олон улсад хэрэглэгдэж буй дугуйн замын стандартыг судалж үндэслэл болгох.</li> <li>➤ Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол 2030 оны хөгжлийн чиг хандлага, Улаанбаатар хотын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөө, тухайн нутаг дэвсгэрийн шинээр болон өргөтгөл шинэчлэлт хийгдэж буй төсөл арга хэмжээнүүдтэй уялдуулах, “Дугуйн зам” дэд хөтөлбөрийн Сэлбэ голын дагуух унадаг дугуйн замын судалгааны трассыг үндэслэж Сүхбаатар дүүргийн 13,14,15,16,17,19 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн хүрээнд трасс сонголтыг судалж зураг төслийг боловсруулах.</li> <li>➤ “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил “БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах</li> <li>➤ Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглалын ажлыг өндрийн хэмжилтийн UTM системд хийж тайланг батлуулан хүлээлгэн өгөх.</li> <li>➤ Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрт хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон хөрсний шинж чанараас шалтгаалан суурийг оновчтой сонгох. /Газрын нөхцөлөөс хамаарч тус судалгааг хийх/</li> <li>➤ Гадаргуугийн ус зайлуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх, ус зайлуулах байгууламжийг цогцоор нь шийдэх.</li> <li>➤ Дугуйн замын үндсэн элементүүд болох зорчих хэсэг, дугуйн зогсоол, амралтын талбай, явган хүний гарц, ногоон байгууламж, гадаргуугийн ус зайлуулах</li> </ul>	

байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг иж бүрнээр төсөллөх.

- Дугуйн замын трассад орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлуулах бол тусгах.
- Уулзвар, гарц дээрх хөдөлгөөн зохион байгуулалтыг онцгойлон анхаарах, дугуйн замыг үргэлжилсэн байдлаар төлөвлөх.
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгаж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх
- Авто замын гэрэлтүүлгийг төлөвлөлт хийж, хүчин чадлыг тодорхойлсны дараа тухайн зөвлөх нь “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК руу бие даан хандаж /өргөдлийн маягт бөглөх/ техникийн нөхцөл авч /эх үүсвэрийг тодруулах/ ажлын зургийг боловсруулах. Одоо байгаа гэрэлтүүлгийн шонг шилжүүлэх, дэд станцыг шилжүүлэх зэрэг холбогдох асуудлуудыг мөн шийдвэрлэсэн байх /гудамж замын онцлогт байдлаас хамаарч гэрэлтүүлэгтэй эсэхийг шийдэх/
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:

Дэвсгэр зураг	1:250-1000
Хөндлөн огтлол	1:20-100
Өндөржилт	1:500-1000
Уулзвар, огтлолцол	1:250-500
Бүтээц	1:20
- Дугуйн зам, дугуйн зогсоол, амралтын талбай, сүүдрэвч, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн ажлын тайлан, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, орчны тоймыг харуулсан 3D зураг, төслийн танилцуулга, бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 2ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ хүлээлгэж өгнө
- Тухайн замын үндсэн элементүүдийг (дугуйн зам, гүүр хоолой, зогсоол, хөдөлгөөн зохион байгуулалтын тэмдэг тэмдэглээ, инженерийн шугам сүлжээ, ус зайлуулах байгууламж гэх мэт) Layer тус бүрээр нь салгаж Autocad файлаар өгөх.
- Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар, Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын авто замын зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын дагуу зураг төслийг боловсруулах.
- Дугуйн зам төлөвлөлтийн шатанд буюу дугуйн замын дэвсгэр зургийг Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, Геодези, Усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй тус тус зөвшилцсөний үндсэн дээр холбогдох газруудаас санал авч зураг төслийг баталгаажуулах.

**Хянасан:**

НАЗХГ-ын Орлогч даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч

  
..... /Э.Мөнх-Од/

НАЗХГ-ын БХХ-ийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч

  
..... /Ө.Энхбаатар/

НАЗХГ-ын БХХ-ийн ахлах мэргэжилтэн

  
..... /Б.Анхбаяр/

**Боловсруулсан:**

НАЗХГ-ын БХХ-ийн мэргэжилтэн

  
..... /Г.Мөнх-Эрдэнэ/

2020 оны 07 сарын 03-ны өдөр


НИЙСЛЭЛИЙН АВТО  
ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Газрын байршил

Газрын зориулалт

Сүхбаатар дүүрэг, 13,14,15,16,17,19  
дүгээр хороо

Дугуйн зам



**Таних тэмдэг**

Төлөвлөж буй дугуйн зам 1-р хэсэг

Төлөвлөж буй дугуйн зам 2-р хэсэг

Хянасан:

НАЗХГ-ын БХХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.....*[Signature]* / О.Энхбаатар/

НАЗХГ-ын БХХ-ийн ахлах мэргэжилтэн.....*[Signature]* /Б.Анхбаяр/

Боловсруулсан:

НАЗХГ-ын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн.....*[Signature]* /Г.Мөнх-Эрдэнэ/